

Tom.X  
Fasc.14

Малын тэжээл бэлтгэж ирсэн монголчуудын түүхэн уламжлаас

Л.Чулуунбаатар

Товч утга: Энэ огцүүлэлд мал сургийг осгөх нэг хүчин зүйл болсон малын тэжээлийн тухай товч авч үзсэн болно. Малын тэжээл бэлтгэж ирсэн түүхэн уламжлал бол оргон цар хүрээтэй, олон тайлтай асуудал мөн

Тулхүүр үг: Газрын доройтол, мал, хужир, зоодой, багсармал

Эдүгээ дэлхий дахины хэмжээнд болон монгол улсын хувьд байгаль, газар орон, ус, цаг уурын ихээхэн өөрчлөлт явагдаж, цөлжилтийн тухай их ярьж байна. Албан ёсны мэдээллийн эх үүсвэрээс авч үзэхэд, монгол орны нийт газар нутгийн 70 гаруй хувь нь цөлжилтөнд ямар нэгэн хэмжээгээр хамрагдсан, бэлчээрийн өвс ургамлын зүйлийн бүрэлдэхүүн ихээхэн ядуурч, шимт чанар нь буурсан ажээ. Энэ бол нүүдэлч удмын монголчуудын хувьд аж төрөх хэв маягаа эргэж харах, шинэ нөхцөлд өөрчилж зохицуулахыг бодиттойгоор шаардаж байгаа бус уу. Дэлхийн банкнаас санхүүжүүлж, манай оронд хийсэн судалгаагаар, монголд газрын доройтол гүнзгийрч, энэ нь байгалийн хүчин зүйлээс илүүтэйгээр хүний буруутай үйл ажиллагааны үр дагавартай холбоотой болохыг нэгэнт тогтоосон билээ. Иймээс миний бие монголын байгаль экологийн асуудал, мал аж ахуйн түүхтэй холбогдсон судалгаандаа тулгуурлан, энэ удаа монгол дахь газрын доройтлын шалтгааныг товч хөндөж, малчин монголчууд мал сүрэгтээ тэжээл бэлтгэж ирсэн түүхэн уламжлаас товч өгүүлэх гол зорилт тавьсан юм.

Газрын доройтлын тухай асуудал бол маш өргөн цар хүрээтэй, хамшинж бүхий цогцолбор ойлголт билээ. Олон мянган жилийн турш манай нутаг дэвсгэрт оршин амьдрагсад нүүдлийн мал аж ахуй гол эрхлэж, өвсний сорог, усны тунгалагийг даган отор нүүдэл хийсээр ирсэн уламжлалтай. Нүүдлийн мал аж ахуй нь байгаль хамгаалах нэгэн арга гэж эрдэмтэд судлаачдын бичсэнтэй би санал нэг байна. Харин сүүлийн хэдэн зууны туршид сүм хийд, хурал номын газар олширч, улмаар өнгөрсөн зууны дунд үеэс монголд хотжих үйл явц эрчимтэй өрнөж, зам харгуй их болж, атар газар эзэмших үйл явцтай уялдан тариалангийн талбай үлэмж нэмэгдэж иржээ. Энэ бүхэн нь төв суурин газрын агаар, ус, газрын хөрс бохирдон, үхширмэл газар өргөжин тэлэхэд

хүргэсэн байна. Хөдөө орон нутагт малын тоо толгой их өсөж, бэлчээрийн талбай талхагдаж, даац, нөөц нь буурсаар, бас дэлхийн цаг уурын дулаарал, хуурайшилттай холбогдон бэлчээрийн өвс ургамлын зүйлийн бүрэлдэхүүн өөрчлөгдөн, хогийн ургамал элбэгшиж, шимт чанар нь дорийтох төлөв байдалд орсон байна.

Иймээс газрын доройтлын уг шалтгааныг эргэцүүлж үзвээс, газрын хөрсний үе давхрага ихээхэн гүн, олон хэсэгтэй хэдий ч түүний өнгөн хөрсөнд бэхлэгдсэн ургамлын үндэс нь тун нимгэн буюу дээд хэсэгт ердөө л 3-5 см-т байдаг ажээ. Иймээс хур чийг нэн ховордсон үед ургамлын үндэс нөхөн төлжих чадвараа нэгэнт алдаж хатаж хатингартаж үхширдэг байна. Газрын хөрсөн дээр ил ургасан ургамал нарны илчинд хатаж хуурайшин шим тэжээлээ алдаж шарлаад, улмаар цайрч, салхины хүчтэй үлээлтэнд зарим хэсэг нь унаж үрэгдэхээс гадна хөрсөнд бэхлэгдсэн иш, үндсээ ганхуулсаар суларч, элс шороонд дарагдах, хог ургамалд автах маягаар цөлжилтөнд нэрвэгддэг. Энэ үйл явцыг газрын доройтол гэж нэрлэдэг. Газрын доройтол гүнзгийрэхэд олон хүчин зүйл нөлөөлдгөөс хүний хүчин зүйл голлох рольтой юм. Учир нь хүмүүс байгалиас авах, хот суурин, зам, үйлдвэр уурхай, ашигт малтмалын орд зэргийг ашиглах нь их, тэгэхдээ бараг нөхөн сэргээлтгүй, үрлэгэн байдлаар хандаж ирснээс гол булгийн ус ширгэж, агаарын даралт ихээхэн нэмэгдэж, үүлших үйл явц нэн багасаж, хурын үүл гарсан ч агаарын их даралтыг давж хур бороо орж чадахгүй, газар дээр их хүчтэй салхи, шороон шуурга дэгдэж, тэнгэр дэх үүлийг хөөж зайлзуулахаас гадна элс шороонд ургамлын нөмрөг дарагдах явдлыг түргэтгэж өгдөг байна. Хэрэв бороо орвол тэр нь түр зуурын, хүчтэй аадар учраас ус нь амархан урсаж, газрын хөрсөнд шингэж амжилгүй, хурдан зуур ууршиж алга болдог. Нэгэнт гол горхины ус нэн багасаж ширгэсэн нөхцөлд газрын гүний усны түвшин бүр дошилж, өнгөн хөрсний усны нөөцийг нөхөн сэргээх боломжгүй болж тасардаг зүй тогтолтой. Энэ нь өнөө үед хөдөөгийн гар худгийн ус амархан шавхагдаж, ундарга нь үлэмж их удаж байгаагаар илэрч байна.

Газрын доройтол гүнзгийрч байгаагийн бас нэг шалтгаан нь өнгөн хөрсний бүр дээд хэсэгт байдаг хөрсний үржил шимийг тэтгэгч бичил үе давхрага хүчтэй салхинд хийсэж алга болсонтой холбоотой. Иймээс өвс ургамлын гарц муу, тачир сийрэг, шимт чанар ихээхэн буурч, хамар сэнгэнэсэн сайхан хурц үнэр нь ердөө байхгүй болжээ. Энэ байдал манай орны.gov, тал хээрийн бүсэнд бүр 1980-аад оны үеэс маш тод илэрч, эдүгээ нийт нутаг дэвсгэрийн дийлэнх хэсгийг хамарч байна. Энэ учраас өнөө хэр хадаглагдаж үлдсэн хөрсний бичил үе давхрагыг сэргээх, нөхөн төлжүүлэх нэгэн арга нь бэлчээрийн талбайн тодорхой хэсэгт олон наст ургамлын үр цацах, усжуулах, хашаалж хамгаалах явдал болов уу гэж үзэлтэй.

Ийнхүү газрын доройтол ихсэж, хөрсний үржил шим муудаж, өвс ургамлын зүйлийн бүрэлдэхүүн ядуурсан нөхцөлд мал сүргийг сайн тарга хүч авахуулах, ашиг шимиийг арвин байлгахад нэг гол хүчин зүйл нь олон төрлийн тэжээл бэлтгэх, мал аж ахуйг эрхлэх тогтолцоог ч эргэн харах шаардлагатай юм.

Монголын түүхийн бүхий л үеийн туршид нүүдлийн мал аж ахуй хүн ардын ахуй амьдрал, улс орны хөгжилтөнд ихээхэн үүрэг гүйцэтгэсээр ирсэн учраас мал аж ахуйг эрхлэн хотлөх арга ухаан ч улам арвижин баяжиж байжээ. Энэ мэдлэг ухааны арвин өв санд малыг тэжээх арга технологи ч холбогдож байгаа билээ.

Мал тэжээх асуудал бол саяхны хэрэг биш. Эрт дээр үеэс эцэж турсан, хэтэрхий эдэлсэн буюу хөгшин мал, нялх төлийт өвс, будаа, гурил, цагаан идээ, сүү, өөх тосоор тэжээж иржээ. Мал аж ахуйн салбарын эрдэмтэд судлаачдын бүтээлээс үзэхэд, малын тэжээлийг гарал үүслээр нь ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээл гэж З хуваасан (1:22) байдаг. Бас өвс, сүрэл, лай зэрэг бүдүүн тэжээл, их хэмжээний ус агуулсан чийглэг тэжээл, үндсэн ба булцуут үртэн, дарш зэргийг хамааруулж шүүст тэжээл, их төлөв үйлдвэрийн аргаар бэлтгэсэн багсармал тэжээл, малчдын гарг элбэг байх сүү орлох тэжээл гэж олон төрлөөр малын тэжээлийг ангилсан байна. Энэ бүхнийг товч дурдаад, онөөгийн нөхцөлд мал тэжээх боломжтой зарим зүйлийг авч үзье.

Манай зарим орон нутагт хужир шүү, давсиг дангаар нь хэрэглэхээс гадна хаягдал зүйлийг хольж малын тэжээл бэлтгэж, хэрэглэж ирсэн өвөрмөц арга туршлага байгаа юм. Тухайлбал, зүүн аймгуудад зоодой гэж нэрлэдэг нэг өвөрмөц тэжээлийг бага зэргийн хужир шүү, үхсэн мал, амьтны хөсрий яс, үнс зэргээр хийж хэрэглэж байсан. Энэ нь хөдөө орон нутагт элбэг олдох хаягдал зүйлийг зориуд цуглувалж, хувхайрсан ясыг нунтаглаж, үнс, хужир шүүтэй холин усаар зуурч, голдоо нүхтэй дугуй хэлбэрээр дэлгэц дээр хатааж, хооронд нь хэлхэн хаврын хахир үед ядарсан болон эх малд идүүлэхээр бэлтгэсэн тэжээл юм. Уг тэжээл нь өртөг зардал багатай, нэг ёсны хүчит тэжээлийн үүрэг гүйцэтгэдэг өвөрмөц онцлогтой. Бас дээр үед тарваганы сайн хodoодыг хатааж тэжээл болгох, цайны шаарыг хаяхгүй хадгалж малдаа идүүлэх, мал, амьтны цус, элэг, өөх, тэр ч байтугай шар тос, шимиийн архийг бүлээтгэж уулгах зэрэг янз бүрийн аргыг их хэрэглэж байжээ. Энэ бүхэн бол малаа тарга хүчийг нь алдагдуулахгүй, жилбэтэй, онд мэнд оруулах, эх малыг илүү тэжээх замаар үр төлийг нь авч, турж эцэж буй малын хүчийг тогтоох гэх мэт олон талын ач холбогдолтой байжээ.

Манай оронд атар газар эзэмшиж, газар тариалангийн салбар эрчимтэй хөгжснөөр малын тэжээлийн ургамал тариалж, дарш бэлтгэх, сүрлийг малд өгөх, тарианы талбайд ургац хурааж дууссаны дараа мал оруулж, хаягдлыг нь

ашиглах болсон юм. Үр тариа хураахад гардаг протейн багатай эслэг ихтэй тарианы ишийг сүрэл гэдэг. Энэ нь малын хоол боловсруулах эрхтний үйл ажиллагааг тохируулахад их ач холбогдолтой ажээ. Мөн холимог, хорголжин, нэмэгдэл тэжээл нь малын өсөлт хөгжилт, тарга хүчинд сайнаар нөлөөлдөг байна. Эдгээр нь багсармал тэжээлийн хүрээнд бэлтгэгддэг, химиин найрлага, орц, хэмжээ зэргээрээ харилцан адилгүй юм. Химиин олон төрлийн бодис агуулагдсан тэжээлийг эрдэс тэжээл гэдэг. Манай хүмүүс хужир шүү, давсиг гол анхаарч, кали, кальци, хүхэр, төмөр, иод агуулагдсан янз бүрийн тэжээлийг төдий л өргөн хэрэглэж байсангүй. Гэтэл мал тэжээхийн бас нэг учир холбогдол нь зөвхөн идэш хоолны үүргээс гадна малын бие организмын хэвийн өсөлт хөгжилт, элдэв эмгэг, соготой болгохгүй байхад оршиж байгаа ажээ. Үхэр ямар учраас яс долоож, хэмэлж явдаг вэ? Бодож үзэх асуудал эндээс урган гарч байгаа болно.

Манай орны нөхцөлд малын тэжээлийн бааз байгалийн бэлчээрт түшиглэж байгаа учраас өвс ургамлын гарц, шимт чанарыг харгалзан, малд нэмэгдэл тэжээл бэлтгэх, түүнийг ашиглах арга технологийг сайн тохируулж, гар аргаар тэжээл бэлтгэх, үйлдвэрлэлийн явцад хийх зайлшгүй шаардлагатай. Энэ нь бас манай орны мал аж ахуйг эрхлэн хөтлөх тогтолцооны өөрчлөлтийг дагаж нэн чухлаар тавигдаж байгаа гэдгийг зориуд тэмдэглэх ёстай.

Ном зохиолд бичснээр, “өвөл хаврын гачиг цагт хөгшин болон нялх малыг тэжээмүй. Бас уналгын морийг тэжээмүй”(2: 22) гэсэн нь малыг тэжээх явдал цаг улирлын ялгаатай, бас малын төрөл, тарга хүчний байдал зэрэгтэй холбоотой болохыг харуулж байна. Ер нь “XVIII зууны үеэс зарим орон нутагт агь, шаваг, шимт ургамлын үндсийг ухаж усанд буцалгах, хөх бог хамах, гол горхи, нуур цөөрмийн зүлэг, өлөнг хадаж хатаах, модны холтос навч түүж цуглуулдаг байжээ. Энэ үндсэн дээр XIX зууны үеэс шилмүүс, агь, гоёо, халгай, таанын сорс, цулхир, мангир, нохойн хошуу, бор бударгана, зэрлэг сонгино зэрэг ургамлын гаралтай тэжээл бэлтгэдэг болжээ. Харин нэгдлийн үед сүрэл, хивэг, хошуу будаа, арвай буудай зэрэг хүчтэй тэжээлийг төвлөрсөн цэгт үйлдвэрлэдэг байв. Мөн дээр үеэс махны гурил, ясны гурил, шөл, цус, элэг, адуу тарваганы өөх, тарваганы хodoод, загасны шөл, малын сэвэс, адууны халтар хомоол, цайны шаар зэрэг амьтны гаралтай тэжээлээс гадна аарц, цагааны ханд, шар сүү, тосны гүзээ, шар тос зэрэг сүүн гаралтай тэжээл, хужир, эрдсийн зоодой, давс хужрын шахмал мэтийн эрдэс тэжээлийг малчид өөрсдөө бэлтгэж хэрэглэж иржээ” (3: 302).

Зах зээлд шилжиж буй өнөөгийн нөхцөлд манай зарим малчид малын тэжээл бэлтгэхгүй, зөвхөн байгалийн бэлчээрт гол найдаж байгаа нь тийм ч найдвартай биш юм. Ган зуд, байгалийн гамшиг бол малчны бэлтгэлийг шалгадаг, асар их эрсдэл дагуулдаг хүчин зүйл билээ. Иймээс дээр үеэс

уламжилсан арга ухааны ашигтай зүйлийг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан баяжуулж ашиглах явдал нэн чухал юм.

Манай оронд байгаль, газар орон, ус, цаг уурын нөхцөл эрс өөрчлөгдж байгаа учраас малын тэжээл бэлтгэх явдал мал сүргээ өсгөх, ашиг шимийг нь арвижуулах нэг гол хүчин зүйл болж байна. Мөн манай оронд цөлжилт ихээхэн нэмэгдэж, газрын доройтол гүнзгийрч байгаа болохоор байгалийн арвин хадлан бэлтгэх бодит боломж үлэмж хязгаарлагдаж, малчид, ард иргэд гар аргаар болон үйлдвэрлэлийн явцад малын төрөл бүрийн шимт тэжээл хийж ашиглах зайлшгүй бодит шаардлага зүй ёсоор гарч байгаа болно. Иймээс гарын дорхи материалаас эхлээд байгалийн нөөц баялаг, хаягдал зүйлийг ашиглаж малын тэжээл бэлтгэх ажлыг бүх нийтийн үйлс болгох нь зүйтэй гэсэн саналтай байна. Энэ бол малын мах идэж, сүү уудаг хүн болгонд хамаарах учиртай гэдгийг хэлэхэд илүүдэхгүй болов уу.

Манай оронд газар тариалангийн үйлдвэрлэл сэргэж, үр тариа, томс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах нь үлэмж нэмэгдсэн учраас бас малын тэжээл тариалах, дарш бэлтгэх, бүдүүн тэжээл, хивэг, сүрэл сайн ашиглах хэрэгтэй болж байгаа билээ. Малын тэжээл бэлтгэж ирсэн монголчуудын өв уламжлалаас ажиглахад, цайны шаар, гурил, будаа, шөл, яс, сэвэс, хужир шүү, давс зэрэг маш олон зүйлийг тэжээл бэлтгэхэд ашиглаж, тэдгээрийг шаардлагатай цаг үед нь зөв зохистой хэрэглэж, мал сүргийнхээ тарга хүчийг тогтоох, онд мэнд оруулах, ашиг шимийг нь арвижуулах өвөрмөц арга ухааны баялаг өв санг бий болгожээ. Өнөө үед энэ уламжлалт арга ухаанаас суралцах, шинэ нөхцөлд баяжуулан хэрэглэх, шинжлэх ухаан технологийн дэвшлийн ололтыг ч анхааран үзэх зайлшгүй бодит шаардлагатай гэж үзэж байна.

## Дүгнэлт

Энэ өгүүлэлд газрын доройтлын шалтгааныг товч авч үзэж, малын тэжээл бэлтгэх зайлшгүй шаардлагыг онцлон тэмдэглэв. Малын тэжээл бэлтгэж ирсэн монголчуудын түүхэн уламжлалаас санаа авах зүйл их байна. Өнөөгийн нөхцөлд малын тэжээл бэлтгэх ажлыг бүх нийтийн үйлс болгох ёстай.

**Abstract:** In this article we have considered the reason behind land degradation and indicated that the urgent need of fodder preparation. There are many ideas to get from historical tradition of Mongolians who have prepared fodder throughout the years. Currently we must make odder preparation into nationwide cause.

## Ашигласан ном зохиолын нэрс

1. Мал маллагааны арга УБ., 1981
2. Ц. Насанбалжир. Монголын аж ахуй хөтөллөтийн уламжлал, шинэтгэл (XIX зууны эцэс, XX зууны эхэн ) УБ., 1978
3. Монгол улсын түүх ( Түүх, онол- арга зүйн асуудлууд ) УБ., 2006
4. Б. Буянчуулган. Аж ахуйн тэмдэглэл УБ., 1936
5. БНМАУ-ын мал аж ахуйг эрхлэх систем УБ., 1982
6. Хэбэй вангийн аж төрөхийг заасан сургаал болой УБ., 1990
7. Монгол орны бэлчээрийн мал маллагааны арга туршлага УБ., 1966
8. М. Балдан. Мал маллагааны зарим арга УТТА, ф. 15, д. 2, хн. 48
9. Харьят хошууны дотор дагаж явуулахаар тогтоож тушаасан ухуулах бичгийн эх УБ., 1959
10. Ким Жон Рэ. Их шуурганаар сийлэгдсэн түүх УБ., 1999